

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл -ийн хувь
					Эхний хагас		
Стратегийн зорилт 7. “Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт хэрэгжилтэд аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зөвлөмж өгөх”							
	Зорилт1. “Яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх” олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх.	Улсын төсөв, цалин	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	11	5	“Яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх” ажлууд хийгдэж байна.	
1.1	Сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн хөрөнгийн зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад эрсдэлд суурилсан дотоод аудит хийж, зөвлөмж өгч, удирдлагыг мэдээллээр хангах	Улсын төсөв, цалин	Дотоод аудитын олон улсын стандарт, аргачлалын дагуу хийгдсэн байх	-	-	Сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөсөн.	-
1.2	Дотоод аудитын 2025 оны дунд хугацааны төлөвлөгөө баталж, Сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад эрсдэлд суурилсан дотоод аудит хийж, зөвлөмж өгөх.	Улсын төсөв, цалин	Батлагдсан дотоод аудитын төлөвлөгөө, Дотоод аудит хийсэн тоо	1	1	Дотоод аудитын хорооны 2025 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар дотоод аудитын 2025 оны дунд хугацааны төлөвлөгөөг 1 дугаартай тогтоолоор баталсан. Төлөвлөгөөнд заасны дагуу Үндэсний аудитын газрыг мэдээллээр ханган ажиллаж байна.	100%

1.3	Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан, агентлаг, харьяа салбар байгууллагууд, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьсан баримтыг Үндэсний аудитын газарт хүргүүлэх	Улсын төсөв, цалин	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	1	-	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцад Үндэсний аудитын газраас өгсөн дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1299 дугаартай албан бичгээр нэгтгэл төлөвлөгөөг хүргүүлсэн. Мөн харьяа, салбар байгууллагад төлөвлөгөөний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой хяналт тавих тухай 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/1087 дугаар албан бичиг хүргүүлсэн.	100%
1.4	Сайд, Төрийн нарийн бичгийн даргын А ангилалд хамаарах төсөв санхүүтэй холбогдон гарсан тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.	Улсын төсөв, цалин	Гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлсэн дотоод албан бичгийн тоо	2	-	Сүүлийн хагас жилд төлөвлөсөн.	
1.5	Яам болон түүний харъя, салбар байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргах	Улсын төсөв, цалин	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	6	3	Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсыг 2023 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд Үндэсний аудитын газраас аудитаар өгсөн 7 акт, зөвлөмжийн биелэлтийг Сангийн яамны Fas.audit.mn системээр тайлагнасан. Мөн Яам болон түүний харъя, салбар байгууллагын 2-р улирлын шилэн дансны тайланг нэгтгэж сангийн яамны шилэн дансны системээр нэгтгэл тайланг илгээсэн.	100%
1.6	Байгууллагад ирсэн хөндлөнгийн хяналтын зөвлөмжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хянах, зөвлөмж гаргах	Улсын төсөв, цалин	Гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлсэн албан бичгийн тоо	-	1	"Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний биелэлт, Улсын хөрөнгө оруулалтын биелэлт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн биелэлттэд хамааралтай нэмэлт судалгаа, тайлбар баримтуудын хамтаар 2025 оны 01 дүгээр сарын 16-23-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлэн ажилласан.	100%

1.7	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа болон салбар байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх.	Улсын төсөв, цалин	Байгууллагын тоо	2023 онд нийт 3 байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.	2 /ТЦҮГ, УДТ/	Монголын Цахилгаан холбоо ХК-д 2024 оны А/59 дүгээр тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөр гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Харьяа болон салбарын нийт 7 байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмжийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 1 дүгээр улирлын байдлаар тайланг байгууллага тус бүрд хүргүүлсэн.	100%
1.8	Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа болон салбар байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх аргачлал, дүрэм, журмыг шинэчлэн батлуулах.	Улсын төсөв, цалин	Батлагдсан журмын тоо	1	1	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлж байгаа тул журмын дагуу харьяа салбар байгууллагад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг дахин батлуулахаар ажиллаж байна. Тодруулбал Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас журмын хэрэгжилтийн сургалтыг 6 дугаар сард зохион байгуулсан. Үүнтэй холбоотойгоор тус ажлыг сүүлийн хагас жилд багтаан гүйцэтгэхээр байна.	-
Зорилт2. "Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх" зорилтын хүрээнд.		Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	0	Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх зорилгын хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.	
2.1	Яамны ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргасан тайлангийн хамтаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байх, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулсныг хянаж, баталгаажуулахад бэлтгэсэн байх.	Улсын төсөв, цалин	Засгийн газрын үнэлгээний системд тайлагнасан байдал, хүргүүлсэн	Засгийн газрын үнэлгээний системд тайлагнасан, 1 албан бичиг хүргүүлсэн	1 1	Яамны 2024 оны жилийн эцсийн байдлаар ил тод байдалд хяналт-шинжилгээ хийж, 99.14 хувиар үнэлгээ хийж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1357 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт биелэлтийг хүргүүлсэн. Мөн хяналт-шинжилгээ,	100%

			албан бичгийн тоо			үнэлгээний цахим системд 2025.01.03-ны өдөр тайлагнасан.	
2.2	2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх	Улсын төсөв, цалин	Гарсан дүгнэлт, зөвлөмжийг яамны нэгжүүдэд танилцуулах	2024 онд ЗГХЭГ-т 1 бичиг хүргүүлсэн.	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний Стратеги төлөвлөгөөний 2022-2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн.	100%
2.3	Байгууллагын 2024 оны жилийн эцэс, 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн баримт бичгийн тоо	2	1	Яам болон харъя, салбар байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж удирдлагын зөвлөлд танилцуулсан. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	100%
2.4	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх.	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Албан хаагчдын сургалт нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан болон танилцуулгыг Засгийн газрын new.unelgee.gov.mn цахим санд хуулийн хугацаанд тайлагнасан.	100%
2.5	Яам, агентлаг, салбарын байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд хариуцсан ажлын чиглэлээр сургалт зохион байгуулна	Улсын төсөв, цалин	Зохион байгуулсан сургалтын тоо	2	1	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлж байгаа тул журмын дагуу харьяа салбар байгууллагад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг дахин батлуулахаар ажиллаж байна. Тодруулбал Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас журмын хэрэгжилтийн сургалтыг 6 дугаар сард зохион байгуулсан. Иймээс журмын хэрэгжилттэй холбоотой сургалтыг 2025 оны сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөж байна.	-
Гурав: "Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн		Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн	9 11	5 35	Эхний хагас жилд төлөвлөгдсөн Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайлангуудыг холбогдох дээд шатны байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн.	

шууд захирагчид тайлагнах" зорилтын хүрээнд.			баримт бичгийн тоо, системд оруулсан тоо				
3.1	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн биелэлтэд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байх.	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллага д хүргүүлсэн баримт бичгийн тоо	1	-	Сүүлийн хагас жилд төлөвлөсөн.	-
3.2	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох байгууллагад хүргүүлсэн байх, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулан баталгаажуулсан байх.	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллага д хүргүүлсэн баримт бичгийн тоо, системд оруулсан тоо	2024 оны 01 дүгээр сард багтаан биелэлтийг цахим системд баталгаажуулж цаасаар ЭЗХЯ-д хүргүүлсэн.	1 1	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан 3 зорилт 6 арга хэмжээг нягтлан үзэж, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн 2024 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 96.67 хувьтай гэж дүгнэж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1396 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг үнэлгээний нэгдсэн системд 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөр баталгаажуулсан.	100%
3.3	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024, 2024-2028 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулсан байх.	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллага д хүргүүлсэн баримт бичгийн тоо, системд оруулсан тоо	2024 оны 1, 6 дугаар сард багтаан биелэлтийг баталгаажуулж цаасаар ЗГХЭГ-д хүргүүлсэн. Мөн цахим системд 2024 онд нийт 10 удаа тайлагнасан.	1 3	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний биелэлтэд эцсийн хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 сарын 31-ний өдрийн 03/1400 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний удаагийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын monitoring@ags.gov.mn хаягт албаны хаягаар 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр илгээсэн.	100%

3.4	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулсан байх.	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо, системд оруулсан тоо	2024 оны 1, 6 дугаар сард багтаан биелэлтийг баталгаажуулж цаасаар ЭЗХЯ-д хүргүүлсэн. Мөн цахим системд 2023 онд нийт 6 удаа тайлагнасан.	1 3	Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн эцсийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1385 дугаартай албан бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Мөн 2025 он гарснаас хойш цахим системээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг 1 удаа тайлагнасан. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хагас жил тутам 1 удаа тайлагнахаар байна. Сар бүр цахим системээр тайлагнах шаардлагагүй болсон.	100%
3.5	Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сар бүр www.new.unelgee.gov.mn цахим хаягт оруулах, жилд 2 удаа биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж гаргасан тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт бичгээр хүргүүлсэн байх.	Улсын төсөв, цалин	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо, системд оруулсан тоо	2024 оны 1, 6 дугаар сард багтаан биелэлтийг баталгаажуулж цаасаар ЭЗХЯ-д хүргүүлсэн. Мөн цахим системд 2023 онд нийт 13 удаа тайлагнасан.	1 6	2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн биелэлтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 03/1291 дугаартай албан бичгээр илгээсэн. Түүнчлэн цахим системд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 4 удаа цахим системд тайлан оруулсан. Мөн Засгийн газрын 2025 он 43 дугаар тогтоолоор уг тайланг улиралд 1 удаа цахим системээр тайлагнах эрх зүйн зохицуулалттай болсон. Түүнчлэн хагас бүтэн жилээр тайланг цаасан хэлбэрээр илгээхээр байна. Өөрөөр хэлбэл журмын дагуу жилд 4 удаа тайлагнахаар болсон.	100%
3.6	Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах.	Улсын төсөв, цалин	ЗГХЭГ-т хүргүүлсэн албан бичгийн тоо, Дүгнэлт, зөвлөмжийг танилцуулсан аймгийн тоо	2024 онд 22 гэрээний хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн аймаг, Нийслэлийн Засаг даргад гарсан дүгнэлт	1 22	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 21 аймаг, нийслэлийн биелэлтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.	100%

				зөвлөмжийг танилцуулсан.			
Зорилт4. “төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд.		Улсын төсөв, цалин	Албан бичиг шийдвэрлэлтийн тоо, ХХНЖ-д заасан баримтыг бүрдүүлж өгсөн тоо	-	-	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн 63 албан бичиг, иргэний 1 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	
4.1	Нэгжид хуваарилагдсан баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавих, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах, хяналт тавих.	Улсын төсөв, цалин	Албан бичиг шийдвэрлэлтийн тоо, ХХНЖ-д заасан баримтыг бүрдүүлж өгсөн тоо.	-	-	Нэгжид хуваарилсан бичиг тус бүрийг шийдвэрлэн ажиллаж байна. Архивын албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу нэгжийн 3 албан хаагч ХХНЖ-д баримт хүлээлгэн өгөхөөр тусгасан.	50%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ.

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ.

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Үнэлгээ
			Эхний хагас		
1	2	3	4		5
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
Зорилт 21.Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ		Тоогоор	3	Доорх хэрэгжилтээр.	
1.	Худалдан авах ажиллагааны сургалтад сурч, төгссөн байна.	Амжилттай төгсөгчдийн тоо	3	Сургалтад хамрагдаж, АЗ гэрчилгээг хугацаагүйгээр авсан.	100%
2.	Төрийн албаны сургууль Удирдлагын академийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдана.	Төгссөн албан хаагчдын тоо	-	Нэгжийн албан хаагчид бүгд хамрагдсан.	100%
3.	Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдана.	Хамрагдсан албан хаагчийн тоо	-	Байгууллагаас зохион байгуулсан бүхий л сургалтад болон компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдсан.	100%

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төсвийн шууд захирагч

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

П.АЛТАН-ОД

(огноо)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Нэгжийн дарга

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

.....

Д.БАТБИЛЭГ

(албан тушаал)

(гарын үсэг)


(огноо)

Тайлагнасан:

Нэгжийн дарга

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

/...../
(албан тушаал)



(гарын үсэг)

Ц.БОРХҮҮ

(огноо)